

Сайн Самари хүн

-The Good Samaritan-



48Page

Тайлбарлагч Нэгэн хуульч хүн Есүсийг сорихоор ингэж асуув.

Хуульч Би мөнх амийг өвлөн авахын тулд яах ёстой вэ?

Есүс Хуульд юу гэж бичигдсэн байдаг билээ?

Хуульч Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадал, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла

Есүс Чи зөв хариуллаа. Үүнийг үйлдвэл чи мөнх амьтай болно.

Тайлбарлагч Харин тэр өөрийгөө зөвтгөх гэж Есүсээс асуув.

Хуульч Тэгвэл миний хөрш гэдэг чинь хэн билээ?

Тайлбарлагч Тэгтэл Есүс нэгэн түүх ярьж өгөв.



49Page

Есүс Нэгэн хүн Иерусалимаас Иерохо рүү явж байгаад дээрэмчидтэй тааралдлаа.

Дээрэмчин1 Сайхан зүйлийг хуваалцаж бай л даа. Баярлалаа сайн хэрэглэнээ.

Эрэгтэй Болохгүй ээ. Гуйя эргүүлээд өгөөч.

Дээрэмчин2 Энэ чинь үгээр хэлээд ойлгохгүй нь ээ” Май чи! Май чи!!!

Эрэгтэй Ёооё! Яаая! Ёо Ёооооо!

Есүс Дээрэмчид түүнийг нүцгэлэн зодоод амьтай төдий орхиод оджээ.



50Page

Есүс Тэр хүн маш их гэмтэж босож чадахгүй байв. Тэр үед хаанаас ч юм хүн ойртон ирж буй хөлийн чимээ сонсогдлоо. Тэр хөлийн чимээний хүн тахилч байлаа. Тахилч гэдэг нь сүмд тахилын үйлчлэлийг хийдэг хүн байв.

Эрэгтэй /Бодол/ (Тахилч өнгөрч байна. Би одоо аврагдсан !!!)

Намайг авраач, надад тусаач

Есүс Дээрэмдүүлсэн хүн чин сэтгэлээсээ тусламж хүсэв. Гэтэл тэр тахилч тэр хүнийг харсан хирнээ хараагүй юм шиг өнгөрөөд явчихлаа.



51Page

Есүс Хэсэг хугацааны дараа бас хэн нэгэний хөлийн чимээ сонсогдов. Тэр хүн сүмд тахилчийн туслах хийдэг Леви хүн байлаа.

Эрэгтэй /Бодол/ (Леви хүн бол надад тусална)

Надад туслаач. Гуйя.... амь авраач.

Есүс Леви хүн ч бас тэр хүнийг харсан хирнээ өнгөрөөд явчихав.



52Page

Есүс Дээрэмдүүлсэн хүн сүүлдээ хүч нь суларч эхлэв. Гэтэл хэсэг хугацааны дараа өөр чимээ дахин сонсогдож эхлэв. Илжиг унасан тэр хүн Израильчуудад хүн гэж тооцогддогүй, ад үзэгддэг Самари хүн байлаа.

Эрэгтэй /Бодол/ (“Тахилч ч тэр, Леви хүн ч тэр намайг харчихаад зүгээр явчихсан юм чинь энэ хүн юу боллоо гэж надад туслах вэ дээ, бас л өнгөрөөд явах байх”) сүүлдээ бүр хүчгүй болов.... Эцэст нь ингээд зам дээр үхэх байжээ....



53Page

Есүс Дээрэмдүүлсэн хүн ямар ч хүчгүй болж бууж өгөв. Гэтэл юу болсон гээч Самари хүн илжигнээсээ буун түүн рүү дөхөн ирэв.

Самари хүн Яанаа, цус их алдсан байх чинь. Энэ хавьд дээрэмчид ихтэй тул болгоомжтой явах хэрэгтэй.

Есүс Самари хүн эхлээд түүний цусыг болгоомжтой арчиж өгөв. Мөн шархан дээр нь эм түрхэн маш сайн боож өгөв.



54Page

Есүс Самари хүн түүнийг илжигэндээ сундлан дэн буудалд хүрч, тэндээ хамтдаа хоноглоцгоов. Дараа өдрийн өглөө нь Самари хүн дэн буудлын эзэнд мөнгө өгөөд хэлэв.

Самари хүн Би одоо явах хэрэгтэй. Тэр хүнийг сайн асарч халамжлаарай. Би дахиад энүүгээр ирэх болохоор үүнээс их зардал гарвал ирэхдээ төлье

Тайлбарлагч Есүс урт түүхийг дуусгаад өнөөх асуулт асуусан хүнээс асуув.

Есүс За энд гурван хүн байна. Ахлах талхилч, Леви хүн, Самари хүнээс аль нь дээрэмдүүлсэн хүний жинхэнэ сайн хөрш вэ?

Хуульч Түүнд тусласан сайн Самари хүн

Есүс Тиймээ зөв байна. Чи ч бас байгаа газартаа сайн Самари хүн шиг бусдыг хайрлаж, тусалж яв

Тайлбарлагч Есүсийн энэ үгэнд тэр хүний сэтгэл ихэд хөдлөөд буцаж явлаа.